


Батлав. Дархан-Уул Аймгийн Ерөнхий архитекторын
үүргийг түр орлон гүйцэтгэгч



/Х.Олонбаяр/

Архитектур төлөвлөлтийн даалгавар
Дугаар 21/52

Огноо 2021.10.31

Дархан

1	Барилга байгууламжийн байршил тогтоосон газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ.	Дархан-Уул аймгийн ГХБХБГ-н ГЗБТЖТ-ний төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газар. Газрын байршил: Дархан сум, Малчин баг, Хөтөл хороолол Газрын хэмжээ: 1500 м ² Зориулалт: " Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор "
2	Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал.	Худалдаа үйлчилгээний цогцолбор
3	Барилгын хэмжээ.	Барилгын хэмжээг тухайн газрын байдалд тохируулан технологийн шаардлагын дагуу барилгын зураг төсөл зохиогч шийдвэрлэнэ.
4	Барилгын төрөл, давхрын тоо. -дээд хязгаар -доод хязгаар	3 давхар хүртэл
5	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө.	Дархан хотын Ерөнхий төлөвлөгөө
6	Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл.	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний умард бүс
7	Эдэлбэр газрын хэмжээ.	1500 м ²
	Үүнээс: -барилгажих талбай	Олгосон газрын 50 хувь хүртэл
	-Ногоон байгууламжийн талбай	Олгогдсон газрын 50 хувиас дээш
	-Авто зогсоол, зам талбай -Бусад	-
8	Барилгажилтын улаан шугамын зай.	-Хотын төв автозамаас 15 метрээс багагүй зайд төлөвлөх. -Барилга хоорондын зай, шугаман байгууламжийн тусгаарлах зурвасуудыг норм дүрмийн дагуу төлөвлөх. - Барилга угсралтын ажил эхлүүлэхийн өмнө барилгын улаан шугамыг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар тавиулж ГХБХБГ-аар хянуулсны дараа газар шорооны ажлыг эхлүүлэх.
9	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага.	- Орчны барилга байгууламжуудтай уялдуулж төлөвлөх. - Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж хотын авто замын сүлжээнд холбогдохоор төлөвлөлтийн шийдлийг боловсруулах. - Олгогдсон газарт ИШС байрлаж байгаа тохиолдолд түүний тусгаарлах зурваст барилга байгууламж төлөвлөхгүй байх. -Галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой зай хэмжээ, норм дүрмийг төлөвлөлтөд баримтлах.

10	Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага.	Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгуудтай уялдуулж талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх.
11	Архитектур төлөвлөлтийн шаардлага.	- Газар хөдлөлтийн 7-8 баллын бүсэд хамаарагдана. Архитектур төлөвлөлт , фасадны шийдэлд онцгой анхаарч орон зайн өвөрмөц зохиомжтой, дизайны хувьд орчин үеийн хэв маягийг хадгалсан, орчин үеийн барилгын фасадны материалуудыг оновчтой хослуулан хотын үзэмжид нөлөөлөхүйц барилга төлөвлөх шаардлагатай. Барилгын орчныг төлөвлөхдөө экстерерийн материал сонголт, ландшафтны дизайн, гэрэлтүүлэг гэрлэн чимэглэлийн асуудлыг харьцангуй өндөр түвшинд шийдсэн байхыг шаардана. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц гарц, тээврийн хэрэгслийн зогсоол, тусгай тоноглол бүхий ариун цэврийн ерөөг төлөвлөх.
12	Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага.	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдохоор өгөгдсөн техникийн нөхцөлийн шаардлагыг хангах.
13	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл.	-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх. -Тухайн газарт эрүүл ахуйн улсын байцаагчийн шаардлагатай дүгнэлт гаргуулах. -Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэж ажлын зураг хийхэд хөрсний бүтцээс хамаарсан, хөрсний шилжилтийг тооцож газар шорооны ажил эхлэх, газар доорхи болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр ажлын зургийг боловсруулан батлуулж газар шорооны ажил эхлэх. - Гадна тохижилт, зам талбайд гэрэлтүүлэг хийж тохижуулах, зөвшөөрөлгүй хашаа хайс барьж архитектур, хот байгуулалтын орон зайг алдагдуулахыг хориглох ба авто зам болон явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар төлөвлөлтийг боловсруулах.
14	Инженерийн бэлтгэл арга хэмжээ /үерийн хамгаалалт, далан суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ/.	- Талбайн зохион байгуулалтын төсөл болон ажил гүйцэтгэх төслийг хийж батлуулах.
15	Захиалагчийн нэр, хаяг, утас.	Утас:

Боловсруулсан:

ГХБХБГ-ын мэргэжилтэн.  /С.Дарханбаатар/

